



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2013 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 1/12


Улаанбаатар хот

ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ  
ЖУРАМ, БҮТЦИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.13 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Худалдан авах ажиллагааны газрын даргын дэргэдэх орон тооны бус "Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаал гарсантай холбогдуулан уг ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг хуулийн хэлтсийн мэргэжилтэн /Д.Түвшинтулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ю.ИДЭРЦОГТ

1140500100

Нийслэлийн худалдан авах ажиллагааны  
газрын даргын А/31 дүгээр тушаалын  
нэвдүгээр хавсралт

УХА0517 5664225

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ДЭРГЭДЭХ ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Худалдан авах ажиллагааны газрын даргын дэргэдэх орон тооны бус олон нийтийн зөвлөлийн /цаашид Зөвлөл гэх / үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө

1.2. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг тусгах холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж өгөх зорилготой ажиллана.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга, ил тод, хараат бус байх зарчмыг баримтална.

1.4. Зөвлөл нь Худалдан авах ажиллагааны газрын хараат бус байдал, бие даасан үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.

### Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ

2.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах;

2.1.2. Худалдан авах ажиллагааны газар нь хараат бус, ил тод, хууль дээдлэн ажиллаж байгаа эсэхэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

2.1.3. Худалдан авах ажиллагааны газрын бодлого, үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлыг Худалдан авах ажиллагааны газарт уламжлах;

2.2. Зөвлөл нь гүйцэтгэх чиг үүргийнхээ дагуу Худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж өгнө.

### Гурав. Зөвлөлийн бүрэн эрх

3.1. Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааны ил тод, шударга байдлыг үнэлэн зөвлөмж гаргах

3.2. Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний биелэлтийн тухай мэдээлэл, тайлбарыг Худалдан авах ажиллагааны газраас авах.

3.3. Худалдан авах ажиллагааны газарт ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэсэн тухай мэдээлэл авах.

3.4 Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал гаргах

3.5 Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн аливаа асуудлын биелэлтийг дүгнэх

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан /цаашид "хуралдаан" гэх/ байна

4.2. Зөвлөлийн хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа зарласнаар хийх ба гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

4.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга, гишүүд санал болгоно.

4.4. Хүндэтгэх үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадаагүй Зөвлөлийн гишүүн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан саналаа хүргүүлсэн тохиолдолд түүнийг хуралдаанд оролцсонд тооцно. Энэ тохиолдолд Зөвлөлийн дарга хуралдаанд биечлэн оролцож буй гишүүд хэлэлцэж буй асуудлаар саналаа гаргасны дараа саналаа урьдчилан хүргүүлсэн гишүүний саналыг танилцуулж санал хураахад оруулан тооцно.

4.5. Зөвлөл үйл ажиллагааны тайланг жил бүр, Худалдан авах ажиллагааны газарт өгсөн зөвлөмжийг тухай бүрд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

Тав.Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

5.1 Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

5.2 Зөвлөлийн гишүүдийн тоо, ажиллах журмыг нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар батална.

5.3 Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын дарга нь Зөвлөлийн дарга байна.

Зургаа. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

6.1. Зөвлөлийн дарга, гишүүд нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг баримтлан ажиллаж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.1.1 Зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг эдлэхээс гадна дараах бүрэн эрхтэй

6.1.1.1.Зөвлөлийн хуралдааны товыг зарлан зохион байгуулж удирдан явуулах;

6.1.1.2 Зөвлөлийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг хэвлэл мэдээллийн

хэрэгслээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах

6.1.2 Зөвлөлийн гишүүн дараах эрхтэй

6.1.2.1 Зөвлөлийн хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлэх

6.1.2.2 Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар Зөвлөлийн хуралдаан мэдээлэх

6.1.2.3 Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлж, дүгнэх

6.1.2.4 Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын дотоод үйл ажиллагаатай танилцах

6.1.2.5 Зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах

Долоо. Зөвлөлийн гишүүнийг томилж, чөлөөлөх

7.1. Зөвлөлийн гишүүнийг шалгаруулахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласаны дагуу өөрийн хүсэлтийг гаргасан иргэн болон төрийн болон төрийн бус байгууллагын /ашгийн бус/ төлөөлөгчийг худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллах хүсэл сонирхол, туршлага, олон нийтийн эрх ашгийг илэрхийлэх чадвар зэргийг шалгуур болгон, нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас томилно.

7.2. Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө

7.2.1. Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;


7.2.2. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол гарсан;

7.2.3. Зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцохгүй болсон тохиолдолд.

Найм. Бусад зүйл

8.1 Зөвлөл нь энэхүү журам болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн чанд сахин ажиллана.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны  
газрын даргын А/31 бүгээр тушаалын  
хоёрдугаар хэвсрэлт



Олон Нийтийн Зөвлөлийн бүтэц

Д/д	Албан тушаал	Орон тоо
1	Дарга	1
2	Нарийн бичгийн дарга	1
3	Гишүүн	7
Нийт		9